



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захирагааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn; <http://www.city.audit.mn>

2017.2.24 № 408
танай -ны № -т

НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН
ТӨВ ӨРГӨӨНИЙ ЗАХИРАЛ
Б.БАЙГАЛМАА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Нийслэлийн соёлын төв өргөөний 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Нийслэлийн Аудитын газрын захиалгаар “Лайэн -аудит” ХХК аудит хийв.

Нийслэлийн соёлын төв өргөөний удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

“Лайэн аудит” ХХК нь Нийслэлийн соёлын төв өргөөний 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

“Лайэн аудит” ХХК нь аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Нийслэлийн соёлын төв өргөөний 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглувансан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бурдуулсан.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн соёлын төв өргөөний 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ц.ОЧИРБАТ